

## БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГЫН ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТ

### Сурагчдаас авах бүлгийн ярилцлагын чиглүүлэх асуулт

#### *Нэг. Сургуулийн эерэг таатай уур амьсгал*

1. Та нар сургуулиараа бахархдаг уу? Тийм бол юу вэ?
2. Та нар сургуульдаа явах дуртай юу? Яагаад?
3. Сургуулиас зохион байгуулдаг үйл ажиллагаа та нарт таалагддаг уу? Та нарын дуртай ямар үйл ажиллагаа байдаг вэ? Яагаад дуртай байдаг вэ?

#### *Хоёр. Сурагчдын бие махбодийн шийтгэл, хүчирхийллээс хамгаалагдсан байдал*

1. Та нар бие махбодийн шийтгэл, хүчирхийлэл гэдгийг мэддэг үү? Үүнийг юу гэж ойлгодог вэ?
2. Та нар сэтгэл зүйн хувьд айж эмээх, түгших ямар нэгэн дарамттай байдалд орж байсан уу? Тийм бол ямар?
3. Сургуулийн орчинд хүүхдүүд бие махбодийн шийтгэл, хүчирхийллээс хамгаалагдсан байдаг уу? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?
4. Багш нар хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэдэг үү? Ямар аргыг хэрэглэдэг вэ? (Жишээ нь, загнаж зандрахаасаа илүү зөвлөх, тайлбарлах, ойлгуулах, буруу зүйл хийхэд цохиж зоддоггүй байх)
5. Ямар нэгэн асуудал тулгарч багшдаа хандаж чаддаг уу? Тэд та нарт зөвлөн, тусалж чаддаг уу?

#### *Гурав. Сургуулийн орчин дахь дарамт, ялгаварлан гадуурхалтгүй байдал*

1. Та нарыг ялгаварлан хандах тохиолдол байдаг уу? Энэ талаар сургуулиас сургалт, мэдээллийн ажил зохион байгуулдаг уу? (Жишээ нь, нас, хүйс, амьдралын түвшин, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа зэргээр ялгаварлах гэж тайлбарлаж болно).
2. Танай сургуульд казах, тува гээд үндэсний цөөнхийн хүүхдүүд суралцдаг уу? Эдгээр хүүхдийг дэмжсэн сургалт, урлаг соёлын үйл ажиллагаа зохион байгуулдаг уу? (Жишээ нь, үндэсний хэл, соёл, баяр наадам зэрэгт хүндэтгэлтэй хандаж, энэ чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулдаг уу)
3. Та нар багш нартаа бүрэн итгэдэг үү? Багш нар сурагчдын нууцыг хадгалж чаддаг уу?
4. Та нараас дуртай эсэхийг чинь асуулгүйгээр ямар нэгэн үйл ажиллагаанд хүчээр хамруулж байсан уу?

#### *Дөрөв. Өөрийгөө хөгжүүлэх боломж*

1. Сургууль дээрээ спортоор хичээллэх, авьяасаа хөгжүүлэх боломж байдаг уу? Танай сургууль дээр ямар секц дугуйлангууд хичээллэдэг вэ? Энэ талаар мэдээлэлтэй байдаг уу?
2. Секц, дугуйланд ашиглагдах хэрэгслүүд хангалттай байж чаддаг уу? Хэрэгсэл дутагддаг ямар секц дугуйлан байдаг вэ?
3. Интернэт ашиглах боломж сургуулийн орчинд байдаг уу?
4. Сурах бичиг та нарт хангалттай байж чаддаг уу?

#### *Тав. Засаглалын орчин*

1. Та нартай холбоотой ямар дүрэм, журам байдгийг мэддэг үү? Та нарт танилцуулж байсан уу? Тийм бол хэн, хэрхэн, яаж танилцуулсан бэ?
2. Дүрэм журамнаас дагаж мөрдөхөд хэцүү, ойлгомжгүй зүйл байдаг уу? Ямар?

3. Сургуулиас үйл ажиллагаа зохион байгуулах, төлөвлөх, хяналт тавихад та нарын саналыг авдаг уу? Авч байсан бол хэзээ, юунд, ямар байдлаар санал авч байсан бэ?
4. Сургуулийн төсөв боловсруулах, хяналт үнэлгээ хийх зэрэг ажилд сурагчид оролцож байсан уу? Хэзээ, ямар байдлаар, ямар үйл ажиллагаанд оролцож байсан бэ?
5. Танай сургуульд сурагчдын зөвлөл байдаг уу? Тэд юу хийдэг вэ? Та нар оролцдог уу? Хэрэв оролцдоггүй бол яагаад оролцоогүй вэ?
6. Та нар санал хүсэлтээ сургуулийн удирдлагад хүргэдэг үү? Тэд та нарыг сонсдог уу?

## **Эцэг эхээс авах бүлгийн ярилцлагын чиглүүлэх асуулт**

### ***Нэг. Сургуулийн эерэг таатай уур амьсгал***

1. Та нар сургуулиараа бахархдаг уу? Тийм бол юу вэ?
2. Танай хүүхдүүд сургуульдаа явах дуртай юу? Яагаад?
3. Сургуулийн зохион байгуулж байгаа үйл ажиллагаа та нарт таалагддаг уу? Ямар үйл ажиллагаа байдаг вэ? Таалагддаггүй үйл ажиллагаа байдаг уу? Тийм бол яагаад вэ?

### ***Хоёр. Сурагчдын бие махбодийн шийтгэл, хүчирхийллээс хамгаалагдсан байдал***

1. Та бүхэн бие махбодийн шийтгэл, хүчирхийлэл гэдгийг юу гэж ойлгодог вэ?
2. Таны бодлоор сургуулийн орчинд хүүхдүүд бие махбодийн шийтгэл, хүчирхийллээс хамгаалагдаж чаддаг уу? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?
3. Багш нар хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэдэг үү? Ямар аргыг хэрэглэдэг вэ? (загнаж зандрахаасаа илүү зөвлөх, тайлбарлах, ойлгуулах, буруу зүйл хийхэд цохиж зоддоггүй байх)
4. Багш эцэг эхтэй яаж харилцдаг вэ? (хүндэтгэлтэй, нээлттэй, үл тоосон, буруутгасан зэрэг байдал гаргадаг эсэх) Та нар ямар нэг асуудлаар багшид хандаж байсан уу? Тэд зөвлөн, тусалж чаддаг уу?
5. “Багшийн ёс зүйн дүрэм”-тэй танилцаж байсан уу? Таны бодлоор энэ дүрэм сургууль дээр хэрэгждэг үү? Яагаад?

### ***Гурав. Сургуулийн орчин дахь дарамт, ялгаварлан гадуурхалтгүй байдал***

1. Та нарыг ялгаварлан хандах тохиолдол байдаг уу? Энэ талаар сургуулиас сургалт, мэдээллийн ажил зохион байгуулдаг уу? (Жишээ нь, нас, хүйс, амьдралын түвшин, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа зэргээр ялгаварлах гэж тайлбарлаж болно).
2. Танай сургуульд казах, тува гээд үндэсний цөөнхийн хүүхдүүд суралцдаг уу? Эдгээр хүүхдийг дэмжсэн сургалт, урлаг соёлын үйл ажиллагаа зохион байгуулдаг уу? (Жишээ нь, үндэсний хэл, соёл, баяр наадам зэрэгт хүндэтгэлтэй хандаж, энэ чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулдаг уу)
3. Та нар багш нартаа итгэдэг үү? Багш нар сурагчдын нууцыг хадгалж чаддаг уу?
4. Та нараас дуртай эсэхийг чинь асуулгүйгээр ямар нэгэн үйл ажиллагаанд хүчээр хамруулж байсан уу?

### ***Дөрөв. Засаглалын орчин***

1. Сургуулиас эцэг эхэд зориулсан ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг вэ?
2. Сургуулийн төлөвлөгөө боловсруулах, төсөв хэлэлцэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг татан оролцуулдаг уу? Ямар үйл ажиллагаанд оролцож байсан бэ? Сургуулиас зохион байгуулж буй үйл ажиллагаа ямар байгаасай гэж хүсч байна вэ?
3. Та нар сургууль, багшаас ямар мэдээлэл авахыг хүсдэг вэ? Мэдээллийг ямар байдлаар авмаар байдаг вэ?
4. Сургуультай холбоотой мэдээллийг авахад хүндрэлтэй зүйл байдаг уу? Ямар?

## Багш нараас авах бүлгийн ярилцлагын чиглүүлэх асуулт

### *Нэг. Сургуулийн орчин дахь эерэг, таатай уур амьсгал*

1. Та нар сургуулиараа бахархдаг уу? Тийм бол юу вэ?
2. Та нарт ажлаа урам зоригтой хийх боломж бүрдсэн байдаг уу? Яагаад?
3. Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж байдаг уу? Яагаад?
4. Ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэх боломж байдаг уу? Юу саад болдог зүйлс бий юу?
5. Сургуулийн удирдлага багш нарыг урам зоригтой ажиллах талаас нь хэрхэн дэмжиж урамшуулдаг вэ?

### *Хоёр. Бие махбодийн шийтгэл, хүчирхийллээс хамгаалагдсан байдал*

1. Та бүхэн бие махбодийн шийтгэл, хүчирхийлэл гэдгийг юу гэж ойлгодог вэ?
2. Багш нар ажлын байрандаа дарамт, хүчирхийллээс хамгаалагдаж чаддаг уу? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?
3. Та нар хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэдэг үү? Ямар аргыг хэрэглэдэг вэ? (загнаж зандрахаасаа илүү зөвлөх, тайлбарлах, ойлгуулах, буруу зүйл хийхэд цохиж зоддоггүй байх)
4. “Багшийн ёс зүйн дүрэм”-ийг дагаж мөрдөхөд хүндрэлтэй, ойлгомжгүй зүйл байдаг уу? Ямар?
5. Та нар эцэг эхтэй хэрхэн харилцдаг вэ? (хүндэтгэлтэй, нээлттэй, үл тоосон, буруутгасан зэрэг байдал гаргадаг эсэх) Та нарт эцэг эхчүүд ямар нэг асуудлаар ханддаг уу? Тэдэнд зөвлөн, тусалж чаддаг уу?
6. Эцэг эхчүүд багш нартай ямар байдлаар хамтран ажиллаасай гэж хүсдэг вэ?

### *Гурав. Сэтгэл зүйн дарамт, ялгаварлан гадуурхалтаас хамгаалагдсан байдал*

1. Та нар сэтгэл зүйн хувьд айж эмээх, түгших ямар нэгэн дарамттай байдалд орж байсан уу? Тийм бол ямар?
2. Та нарыг ялгаварлан хандах тохиолдол байдаг уу? Энэ талаар сургуулиас сургалт, мэдээллийн ажил зохион байгуулдаг уу? (Жишээ нь, нас, хүйс, амьдралын түвшин, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, жирэмсэн эсэхээр ялгаварлах гэж тайлбарлаж болно). Энэ асуудлаас урьдчилан сэргийлэх талаар үйл ажиллагаа зохион байгуулдаг уу? Энэ чиглэлээр юу хийх хэрэгтэй вэ?
3. Танай сургуульд казах, тува гээд үндэсний цөөнхийн хүүхдүүд суралцдаг уу? Эдгээр хүүхдийг дэмжсэн сургалт, урлаг соёлын үйл ажиллагаа зохион байгуулдаг уу? (Жишээ нь, үндэсний хэл, соёл, баяр наадам зэрэгт хүндэтгэлтэй хандаж, энэ чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулдаг уу)
4. Та нар сурагчдын хувийн асуудалд хэр хүндэтгэлтэй ханддаг вэ? Сурагчдын нууцыг хадгалж чаддаг уу?
5. Та нараас дуртай эсэхийг чинь асуулгүйгээр ямар нэгэн үйл ажиллагаанд хүчээр хамруулж байсан уу?

### *Дөрөв. Засаглалын орчин*

1. Сургууль аливаа үйл ажиллагаа зохион байгуулах, төсөв, төлөвлөгөө боловсруулах, хяналт тавихдаа багш нараас санал авдаг уу? Та нар ямар санал өгч байсан уу? Та нарын санал туссан уу?
2. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар саналаа хэлж чаддаг уу? Та нарын санал тусгагдаж хэрэгжинэ гэдэгт итгэлтэй байдаг уу? Тийм бол яагаад?
3. Сургуулийн удирдлагаас багшийн хөгжлийг дэмжин ажилладаг уу?
4. Сургуулийн төсөв боловсруулах, хяналт тавих зэрэгт багш нар оролцох боломжтой уу?

5. Сургуулийн ямар үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийдэг вэ? Хэн, хэзээ, ямар үйл ажиллагаанд хяналт хийдгийг мэддэг үү? Энэ нь үр дүнтэй байдаг уу?

## **Сургуулийн ажилтнуудаас авах бүлгийн ярилцлагын чиглүүлэх асуулт**

### **Сургуулийн эерэг таатай уур амьсгал**

1. Та нар сургуулиараа бахархдаг уу? Тийм бол юу вэ?
2. Та нар ажилдаа дуртай юу? Ажлаа хийхэд саад болдог зүйл бий юу?
3. Та нарт ажлаа урам зоригтой хийх боломж бүрдсэн байдаг уу? Яагаад?
4. Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж байдаг уу? Яагаад?
5. Сургуулиас та нарыг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулдаг уу? Энэ талаар ямар нэгэн санал байгаа юу?
6. Ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэх боломж байдаг уу? Юу саад болдог зүйлс бий юу?
7. Та бүхэнд хамрагдахыг хүсдэг үйл ажиллагаа, сургалт байдаг уу? (Жишээ нь: хувь хүний хөгжлийн, хүний эрхийн, хөдөлмөрлөх эрх)

### **Бие махбодийн шийтгэл, хүчирхийллээс хамгаалагдсан байдал**

1. Бие махбодийн шийтгэл, хүчирхийлэл гэдгийг юу гэж ойлгодог вэ?
2. Сургуулийн орчинд бие махбодийн шийтгэл, хүчирхийлэл байдаг уу? Үүнээс хэрхэн сэргийлэх вэ?

### **Сэтгэл зүйн дарамт, ялгаварлан гадуурхалтаас хамгаалагдсан байдал**

1. Та нар сэтгэл зүйн хувьд айж эмээх, түгших ямар нэгэн дарамттай байдалд орж байсан уу? Тийм бол ямар?
2. Ажлаа сайн хийхэд удирдлагын зүгээс ямар дэмжлэг хэрэгтэй байдаг вэ?
3. Та нарыг ялгаварлан хандах тохиолдол байдаг уу? Энэ талаар сургуулиас сургалт, мэдээллийн ажил зохион байгуулдаг уу? (Жишээ нь, нас, хүйс, амьдралын түвшин, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, жирэмсэн эсэхээр ялгаварлах гэж тайлбарлаж болно). Энэ асуудлаас урьдчилан сэргийлэх талаар үйл ажиллагаа зохион байгуулдаг уу? Энэ чиглэлээр юу хийх хэрэгтэй вэ?

### **Засаглалын орчин**

1. Сургууль аливаа үйл ажиллагаа зохион байгуулах, төсөв, төлөвлөгөө боловсруулах, хяналт тавихдаа та нараас санал авдаг уу? Юунд, ямар байдлаар, хэрхэн авч байсан бэ?
2. Сургуулийн төсөв боловсруулах, хяналт тавихад та нар оролцох боломж уу?
3. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар саналаа хэлэх боломж байдаг уу? Та нарын санал тусгагдаж хэрэгжинэ гэдэгт итгэлтэй байдаг уу? Яагаад?
4. Сургуулийн ямар үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийдэг вэ? Хэн, хэзээ, ямар үйл ажиллагаанд хяналт хийдгийг мэддэг үү? Энэ нь үр дүнтэй байдаг уу?